



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1-ийн "хөрөнгө оруулалтын сан" гэсний дараа "хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1-ийн "хөрөнгийн бирж" гэснийг "үнэт цаасны арилжаа эрхлэх" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР